

**1993 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ  
ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН  
ЖАГСААЛТ (сүүлийн хагас жилд)**

**1993.05.18.** Монгол Улс Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хооронд соёл, боловсрол, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах хөтөлбөрт Монгол Улсаас тус улсад суугаа элчин сайд Ч. Баатар, Их Британий Гадаад Явдлын яамны соёлын хэлтсийн дарга Н. Элам нар Лондон хотноо гарын үсэг зурав.

**1993.06.22.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан гадаад орнуудын дипломат төлөөлөгчдийн газруудын тэргүүн нарыг Төрийн ордонд хүлээн авч уулзав. Дипломат болон Олон улсын байгууллагын төлөөлөгчдийн газрын ахлагч, БНЭУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Кушок Бакула Ерөнхийлөгч П.Очирбатад баяр хүргэв.

**1993.06.26.** Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсонтой нь холбогдуулан П. Очирбатад ОХУ-ын Ерөнхийлөгч Б. Ельцин, БНХАУ-ын дарга Зянь Зэминь, АНУ-ын Ерөнхийлөгч Б. Клинтин нар баяр хүргэж тус тус цахилгаан утас ирүүлэв. Мөн Ерөнхийлөгч П. Очирбатад НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бутрос Гали баяр хүргэж энэ өндөр хариуцлагатай албан үүргээ биелүүлэх үйлсэд нь бүхий л дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн байна.

**1993.06.29.** Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай энэ 6-р сарын 14--25-ны хооронд АНУ-д ажлын айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Ерөнхий сайд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга ноён У. Кристофертэй уулзаж хоёр орны хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна. Ноён У., Кристофер Монголын төрийн өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг дэмжиж байгаагаа илэрхийлэв. АНУ ын компаниудын капиталыг Монголд оруулахад Засгийн газар нь бүх талын дэмжлэг үзүүлэх бөгөөд үүний тулд хоёр талын хэлэлцээрийг ойрын үед байгуулахаар болов. Мөн АНУ-ын төлөөлөгчдийн танхимаар одоо хэлэлцэж буй «Ардчиллыг дэмжих» тухай хуулинд Монголын талаар тусгай зүйл оржээ. Үүнийг Сенат дэмжинэ гэдгээ мэдэгдэж төрийн зөвлөл анхаарч үзэхээ илэрхийлэв. ОУВС, Дэлхийн банкин дээр ажил хэрэгч уулзалтууд болж Монгол бол эдийн засгаа зах зээлд шилжүүлэх эрүүл хөрсөн дээр хөгжүүлэх талаар шийдвэртэй зоримог ажиллаж байгааг тэд тэмдэглэсэн байна. Монголын эдийн засгийн бүтцийг өөрчлөх хөтөлбөрийг ОУВС-ийн захиргааны зөвлөлийн хурлаар 100 хувийн саналаар баталсан байна.

**1993.07.05.** Батлан хамгаалах яамны Стратегийн судалгааны хүрээлэнгийн урилгаар БНХАУ-ын Олон Улсын Стратеги судлалын хүрээлэнгийн орлогч дарга Ши Ся тэргүүтэй судлаачид хүрэлцэн ирж «Хүйтэн дайны дараах олон

улсын аюулгүй байдал» сэдвээр судалгааны уулзалт хийв. Хоёр орны эрдэмтэд, судлаачид дээрх сэдвийн хүрээнд хэд хэдэн илтгэл хэлэлцэж, харилцан сонирхсон олон асуудлаар санал бодлоо солилцов.

**1993.07.06.** Хууль зүйн сайд Н. Лувсанжав ХБНГУ-ын Шүүх яамны урилгаар саяхан ажлын айлчлал хийж, Монгол, Германы хооронд хууль, эрх зүйн салбарт хамтран ажиллах асуудлаар санал солилцов.

**1993.07.07.** Монгол Улсын Их Хурлын дарга Н. Багабанди тэргүүтэй Монгол Улсын төр засгийн төлөөлөгчид Оросын Холбооны Буриад улсын нийслэл Улаан-Үд хотноо болсон тус улсын 70 жилийн ойн баярт оролцлоо.

**1993.07.10.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар БН Киргиз Улсын Ерөнхийлөгч А. А. Акаев гэргийн хамт манай оронд албан ёсны найрсаг айлчлал хийлээ. Ерөнхийлөгч П.Очирбат, ерөнхийлөгч А. А. Акаев нар Монгол Улс, БНКиргиз Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээнд долдугаар сарын 10-нд гарын үсэг зурав.

**1993.07.16.** Монголын Засгийн газрын урилгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Хатан хаан Элизабет, Эдинбургийн гүнгийн охин, эрхэмсэг гүнж Анна, нөхөр, эрхэмсэг ноён Тимоти Лоренсийн хамт манай оронд энэ сарын 10—14-нд айлчлав. Эрхэмсэг гүнж Анна Монголд байх хугацаандаа Ерөнхийлөгч П.Очирбатад бараалхаж, Ардын хувьсгалын 72 жилийн ойн баяр наадмын нээлт, үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, их насны морины уралдааныг үзэж сонирхов. Мөн Өмнө-говь аймагт өөрийн онгоцоор хүрэлцэн очиж Ёлын ам болон байгалийн түүхийн музей үзэж, тэмээчин айлаар зочилж, Монголын Засгийн газар, Хүүхдийг ивээх олон улсын сангийн хооронд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

--АНУ-ын Засгийн газраас манай улсын түлш, эрчим хүчний салбарт тусламж үзүүлэх тухай хүрээнд 1993 онд 8 сая ам. долларын хөрөнгө гаргах болж энэ гэрээнд сайд Б. Жигжид, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн Монгол дахь төлөөлөгч Уильям Б. Нан нар гарын үсэг зурав.

--БНСУ-ын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны сангаас манай улсад нэг удаагийн тариур, зүүний үйлдвэр барьж байгуулахад зориулан 52 сая орчим ам. долларын хөнгөлөлттэй зээл олгох тухай нот бичигт Монголын Улсын Худалдаа Үйлдвэрийн сайд Ц. Цогт, БНСУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ким Гё Сик нар саяхан гарын үсэг зурав.

**1993.07.23.** Монгол, Украины худалдаа эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан техникийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын комиссын хэлэлцээрийн дагуу ажлын айлчлал хийхээр хүрэлцэн ирсэн Украин Улсын Ерөнхий сайдын орлогч В. И. Евтухов тэргүүтэй төлөөлөгчид Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд П. Жасрай нарт тус тус бараалхав. Төлөөлөгчид хоёр орны 1993, 1994 оны худалдаа, эдийн засгийн хамтын

ажиллагааны протоколд гарын үсэг зурах, геологи эрдсийн баялаг, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах, агаарын харилцааны болон банк хоорондын хэлэлцээ байгуулах юм. Мөн Украины тал Эрдэнэтийн зэсийн баяжмалыг гүнзгий боловсруулах болон Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг хамтран ашиглах сонирхолтой ажээ.

1993.07.24. Улсын Их Хурлын дарга Н. Багабанди, Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай нар Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбооны урилгаар манай оронд ирээд байгаа БНСУ-ын «Кореа фаундэйшн» байгууллагын ерөнхийлөгч Сон Жу Хван, гадаад харилцаа эрхэлсэн гүйцэтгэх захирал Ан Янг Мо, Дангукийн их сургуулийн профессор Ким Хак Жун нарыг хүлээн авч уулзав.

1993.07.28. Зах зээлд шилжиж байгаа манай орны энэ жилийн импортын гол түнш, ОХУ, БНХАУ, АНУ боллоо. 1990 оноос өмнө төвлөрсөн эдийн засгийн үед импортын барааны 75-80 гаруй хувийг хуучин ЗХУ-аас авч байсан юм. Тэгвэл энэ оны эхний хагас жилд импортын бүх төрлийн барааны 10,8 хувийг Орос улсаас, 20,7 хувийг БНХАУ-аас 15,4 хувийг АНУ-аас аваад байна. Манай улс одоо Ази, Европ, Америк тивийн 43 оронтой харилцан ашигтай, гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдаагаар түншилж байна.

1993.07.28. Балбын Вант Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Басудев Чандра Малла Монгол Улсы Ерөнхийлөгч П. Очирбатад итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.07.28. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн энэ 7-р сарын 21 — 27-нд Австралийн Холбооны улсын Засгийн газрын урилгаар тэнд албан ёсны айлчлал хийв. Сайд Ц. Гомбосүрэн Австралийн Гадаад Явдлын яамны сайд Г. Нанстай уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцээ хийлээ. Ц. Гомбосүрэн Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрайгаас Австрали улсын Ерөнхий сайд П. Кийтинг-д явуулсан илгээлтийг гардуулав. Айлчлалын үеэр Австралийн тусламжаар Монголд хэрэгжүүлэх төслүүдийн тухай, хүн сургах болон спортын салбарт хамтран ажиллах тухай гурван төрлийн баримт бичигт гарын үсэг зурав. Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Австралийн парламентын гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга, сенатч Лүүслэй-тэй уулзаж санал солилцов. Уулзалтын үеэр УИХ-ын дарга Н. Багабандиас Австралийн Парламентын спикер С Мартинд явуулсан урилгыг гардуулав.

1993.08.07. Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай Азийн хөгжлийн банкны удирдах захирал М. Анбар тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Монгол орны эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Азийн хөгжлийн банктай хамтран ажиллах талаар санал солилцов. Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай Олон улсын валютын сангийн гүйцэтгэх захирал К. Уотерман тэр-

гүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Олон улсын валютын сангаас ойрын үед Монголтой холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хандивлагч орнуудын зүгээс хийх ажлын талаар санал солилцов.

1993.08.10. Монгол Улсын Их Хурал, ХБНГУ-ын Бундестагийн хамтын ажиллагааны шугамаар ХБНГУ-ын Бундестагийн Байгаль орчныг хамгаалах болон реакторын аюулгүй байдлын байнгын хорооны дарга В. Ф. Гелдерн тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчлав. Төлөөлөгчдийг Улсын Их Хурлын дэд дарга Ж. Гомбожав, Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай нар тус тус хүлээн авч уулзав.

Ноён В. Ф. Гелдерн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчныг хамгаалах байнгын хорооны дарга Ч. Хурцтай уулзан санал солилцов. Тэд «Монгол Улсын Их Хурлын Байгаль орчныг хамгаалах байнгын хороо, ХБНГУ-ын Бундестагийн Байгаль орчныг хамгаалах болон реакторын аюулгүй байдлын байнгын хорооны 1993—1995 онд хамтран ажиллах протоколд гарын үсэг зурав. Монгол Улсаас Филиппин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б. Должинцэрэн 8-р сарын 4-нд Ерөнхийлөгч Фидель В. Рамост итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.08.13. Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбат манай оронд айлчилж байгаа АНУ-ын Конгрессын зарим гишүүдийг хүлээн авч уулзав.

Ерөнхийлөгч П. Очирбат Монгол, Америкийн харилцаа өргөжин хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд манай оронд хийгдэж байгаа шинэчлэл өөрчлөлт, нийгмийн хөгжлийг ардчилах үйлсэд АНУ-ын зүгээс үзүүлж байгаа өргөн тусламжид баяр хүргэлээ. Монгол Улсын Их Хурлын дарга Н. Багабанди Улсын Их Хурлын урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийж байгаа БНХАУ-ын БХАТИХ-ын Гадаад бодлогын байнгын хорооны орлогч дарга Ян Жэнья тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Н. Багабанди хоёр улсын хамтын ажиллагаа, түүний дотор парламент хоорондын харилцаа олон хэлбэрээр өргөжиж байгааг тэмдэглээд энэхүү харилцааг бүх талаар хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлэв.

1993.08.14. Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б. Должинцэрэн Бүгд Найрамдах Сунгапур Улсын Ерөнхийлөгч Ви Ким Ви-д итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1993.08.18. Худалдаа үйлдвэрийн сайд Ц. Цогт Герман Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Райнхард Холубек нар санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэ хэлэлцээрт ХБНГУ-аас 12 сая дойч маркийн хөнгөлөлттэй зээл буюу санхүүгийн буцалтгүй тусламжийг Монгол Улсад үзүүлэхээр тусгажээ.

Герман Улсын Засгийн газар «Дархан хотын эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагааг хангах» тө-

сөлд 9 сая дойч марк, судалгаа шинжилгээний дүнгээр энэхүү төслийг дэмжих нь зүйтэй гэж нотлогдвол уул төслийн дагалдах арга хэмжээг хэрэгжүүлэхэд 600 мянган дойч маркийн, судалгаа шинжилгээний дүнгээр нь эмнэлгийн анхдагч тусламжинд үзүүлэх туслалцаа» төслийг дэмжих нь зүйтэй гэдэг нь тогтоогдвол уул төсөлд 2,4 сая дойч марк хүртлэх хэмжээний санхүүгийн тусламжийг Франкфурт Майн дахь «Кредитаншталт фюр Вийдерауфбау» (Сэргээн босголтын зээлийн банк) -аас ашиглах боломжийг Монголын Засгийн газарт олгох юм байна.

1993.08.24. Монгол Улсын Их Хурлын урилгаар манай оронд айлчилж байгаа ОХУ-ын Буриад Улсын Дээд Зөвлөлийн дарга Л. В. Потапов тэргүүтэй төлөөлөгчдийг Улсын Их Хурлын дарга Н. Багабанди, Ерөнхий сайд П.Жасрай нар тус тус хүлээн авч уулзлаа. Тэд хоёр орны зах зээлийн эдийн засгийн харилцааны шилжилтийн үйл явцтай холбогдсон зарим асуудал, мөн урьд өмнө байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилт, хөдөө аж ахуйн цаг үеийн ажилд харилцан туслах зэрэг асуудлаар санал солилцов.

1993.08.25. Монгол Улсын Засгийн газрын урилгаар манай оронд айлчилж байгаа Азийн хөгжлийн банкны ерөнхийлөгч Япон улсын иргэн, ноён Кимимаса Тарумицуг Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат хүлээн авч уулзав. Тэд макро эдийн засгийн удирдлагад төрийн зохицуулалтын мэдээлэл бүртгэлийг боловсронгуй болгоход болон манай орны эдийн засагт тэргүүлэх ач холбогдол бүхий эрчим хүч, агаарын болон авто, төмөр замыг хөгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны зээл тусламжийг үр ашигтай ашиглах талаар онцгой анхаарч санал солилцов.

Мөн Ерөнхий сайд П. Жасрай ноён К. Тарумицу-г хүлээн авч уулзан Азийн Хөгжлийн банкнаас Монгол улсад олгох зээлийг зарцуулах асуудлаар санал солилцов. Монгол улс, Азийн хөгжлийн банкны хооронд зээлийн гэрээнд Монгол банкны ерөнхийлөгч Д. Моломжамц, Азийн хөгжлийн банкны ерөнхийлөгч, ноён К. Тарумицу нар гарын үсэг зурав. Энэхүү гэрээнд Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад 40 жилийн хугацаатай 30 сая ам. долларыг аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд зориулан олгохоор тусгасан байна.

1993.08.28. Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрайд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Уоррен Кристофер цахилгаан утас ирүүлж «Таны АНУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр уулзаж ярилцсандаа Нэн баяртай байна. Монгол оронд улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хэрэгжүүлж байгаа тухай танаас сонсоход надад туйлын таатай байлаа. Энэ үйлсдээ улам их амжилт олохыг танд болон танай Засгийн газарт ерөөе» гэжээ.

Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбат эх орондоо бүр мөсөн буцах болсонтой нь холбогдуулан АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жозеф Эдуард Лейкийг хүлээн авч уулзан зоог барилаа.

Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай Тайландын

Вант улсын Ерөнхий сайдын тамгын газрын сайд ноён Шинавут Санторисима тэргүүтэй Тайландын Вант улсын Засгийн газрын төлөөлөгчдийг төрийн ордонд хүлээн авч уулзав. Уулзалт ярианы явцад хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсын төрийн болон хувийн хэвшлийн салбарт ажиллагсдыг Тайландад сургах, туршлага судлуулах, монголын эдийд засгийн чухал ач холбогдолтой зарим барилга байгууламжид хөрөнгө оруулах зэрэг асуудлаар санал солилцсон байна.

Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай манай оронд айлчилж буй НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын ерөнхий захирлын орлогч, Ази, Номхон далайн бүсийн төлөөлөгч Абдулла Ханыг хүлээн авч уулзав. Ноён Абдулла Хан мөн Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлдтэй уулзаж хөдөөгийн боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх төслийг боловсруулж, Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, хөрсний үржил шим дээшлүүлэх, ялангуяа хот орчмын тариалангийн талбай малын бэлчээрийг хортон мэргэчдээс хамгаалах энэ чиглэлээр техникийн хамтын ажиллагааны хүрээнд төслийг хэрэгжүүлэх талаар санал солилцсон байна. Мөн монгол малын генийн сан байгуулахаар ярьж тохирсон байна. Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай Японы Засгийн газрын тусламжаар хэрэгжиж байгаа Дорнод аймгийн цавын холимог металлын ордыг ашиглах асуудлаар манай оронд ирсэн Японы металл, уул уурхайн агентлагийн тэргүүлэгч Ногучи Ясуо тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Тэд 1993-94 онд төслийг хэрэгжүүлэх Монгол, Японы эрх бүхий байгууллагуудаас хийж гүйцэтгэх ажлын талаар санал солилцов.

1993.09.07. Монгол улсын Их Хурлын урилгаар Япон улсын парламентын зөвлөхүүдийн танхимын либерал ардчилсан намын бүлгийн ахлагч, танхимын Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга Сайто Жюро тэргүүтэй төлөөлөгчид 8-р сарын 31-нээс 9-р сарын 4-ний өдрүүдэд манай оронд зочлов.

Монгол улсын Ерөнхий сайд П. Жасрай Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн комисс, Япон Монголын эдийн засгийн хоорондын хамтарсан хуралдаанд оролцож байгаа япон, монголын эдийн засгийн хорооны дарга С. Тозаки тэргүүтэй төлөөлөгчдийг төрийн ордонд хүлээн авч уулзав. Тэд монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааг тал бүрээр хөгжүүлэх болон комисс, хорооны зүгээс хамтран зохион байгуулах ажлын талаар санал бодлоо солилцов.

1993.09.11. Монгол улс, БНХАУ-ын хооронд Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол улсын Гаалийн ерөнхий газрын дарга Г. Сэсээр, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын орлогч дарга . Лю-Уньжэ нар гарын үсэг зурав.

1993.09.14 Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Кувейт улсын

Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч, Гадаад харилцааны сайд Сабах аль-Ахмад аль-Жаббер аль-Сабахын бие төлөөлөгч, Кувейтээс БНХАУ-д суугаа элчин сайд Гази Мохаммад Амин аль-Райесийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр бие төлөөлөгч Кубейтийн Гадаад харилцааны сайдын хувийн илгээлтийг сайд Ц. Гомбосүрэнд гардуулав.

1993.09.17. АНУ-аас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Д. Жонсон Монгол улсын Ерөнхийлөгч П. Очир батад итгэмжлэх жуух бичгээ барив.

Япон улсын Ерөнхий сайд М. Хосокава Монголд хандивалгч орнуудын уулзалтад оролцож байгаа Монгол улсын шадар сайд Ч. Пүрэвдоржийг хүлээн авч уулзан, хоёр орны харилцааны асуудлаар санал солилцов. Уулзалтын явцад Ерөнхий сайд М. Хосокава Японы Засгийн газар Монгол дахь ардчиллын үйл явцыг эхнээс нь идэвхтэй дэмжиж ирсэнийг дурьдаад, шинэ Засгийн газар энэхүү чиг шугамыг тууштай үргэлжлүүлэхээ нотлов. Японд болсон Монголд хандивлагч орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагын гурав дахь бага хурал Монгол улсад наад зах нь 150 сая долларын тусламж үзүүлэх шийдвэр гаргаснаар Токиод ажлаа дуусгалаа.

1993.09.18. Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбат «Дэлхийн монголчуудын их чуулган»-д оролцож байгаа. ОХУ-ын Халимаг улсын ардын зохиолч Давид Кугультинов тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Монгол улс, Оросын Холбооны улсын хооронд улсын хилийг шалгах хамтарсан комиссын Оросын хэсгийн дарга Н. В. Павловыг хүлээн авч уулзав.

1993.09.22. Бүгд Найрамдах Казахстан улсын Дээд Зөвлөлийн урилгаар Монгол улсын Их Хурлын дарга Н. Багабанди тэргүүтэй төлөөлөгчид 1993. 09. 18-21-нд Казахстан Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр БНКазахстан улсын Ерөнхийлөгч Н. Назарбаев УИХ-ын дарга Н. Багабанди тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Айлчлалын үеэр Монгол улсын Их Хурал, БНКаз. Улсын Дээд Зөвлөлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт УИХ-ын дарга Н. Багабанди, БНКаз Улсын Дээд Зөвлөлийн дарга С. А. Абдильдин нар гарын үсэг зурав. Хэлэлцээрт гарын үсэг зурсаны дараа Н. Багабанди, С. А. Абдильдин нар айлчлалын үр дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийж, сурвалжлагчийн тавьсан асуултад хариулав.

1993.09.24. Бүгд Найрамдах Турк Улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Айхан Камел Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбатад итгэмжлэх жуух бичгээ барив. Мексикийн Нэгдсэн улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Мануэль Урибе қастаньеда итгэмжлэх жуух бичгээ барив.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат ОХУ-аас тус

улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С. С. Разовыг өөрийн нь хүсэлтээр хүлээн авч уулзав. Элчин сайд төвийнхөө даалгавраар ОХУ-ын дотоод байдлын талаар мэдээлэл хийв. Уг мэдээлэлтэй холбогдуулан ерөнхийлөгч П.Очирбат ОХУ-ын байдлын талаарх Монгол улсын байр суурийг илэрхийлэхдээ «Болж буй үйл явдлыг эв зүйгээр шийдвэрлэх нь Оросын ард түмний төдийгүй олон улсын энх тайван, тогтвортой байдал, улс түмний хамтын ажиллагааны эрх ашигт бүрэн дүүрэн нийцнэ» гэж цохон тэмдэглэв.

Монгол улсын Гадаад харилцааны яамнаас мэдэгдэл гаргав. Уг мэдэгдэлд: ОХУ-ын засаглалын удирдлагуудын хоорондын зөрчил нэн эгзэгтэй байдалтай болж, цаашид үйл явц хэрхэн өрнөх нь тодорхойгүй байна. Оросын ардчилал, шинэчлэлийн хувь заяанд сөрөг нөлөө үзүүлэх вий гэж бид санаа зовж байна. Монголын төр, засгийн газар Орос дахь ардчилал, шинэчлэлийн үйл хэргийг тууштай талархан дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч дэмжихээ нотолж байна. ОХУ-ын төр, засгийн удирдлага, нам, улс төрийн хүчнүүд бий болсон байдлыг эвийн аргаар зохицуулж ардчилал шинэчлэлийн үйл явцыг хамгаалан эрчимжүүлж чадна гэдэгт монголын тал итгэж байна гэж дурьджээ.

1993.09.25. Арабын Социалист Ливи Ард Жамахирээс Монгол улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Муфтах Мади Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбатад итгэмжлэх жуух бичгээ барив.

Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбат «Ардын эрх» сонины урилгаар манай оронд зочилж буй БНСУ-ы ч хамгийн нөлөө бүхий «Дон А Ильбо» сонины ерөнхийлөгч, сонинуудын нийгэмлэгийн ерөнхий захирал Ким Бён Гван тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Ноён Ким Бён Гван «Сонин» компанийн үйлдвэр үзсэн тухай сэтгэгдлээ хуваалцаж үйлдвэрийн шинэчлэлийн асуудлаар өөрийн сонины зүгээс туслалцаа үзүүлэх боломж байгаа тухайгаа танилцуулж зарим тоног төхөөрөмж нийлүүлж болох юм гэдгээ ярив. Гадаад харилцааны тэргүүн дэд сайд Ж. Чойнхор. БНХАУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Пэй Зяиг 1993 оны 9 сарын 22-ны өдөр урьж уулзаад, Хятад улс цөмийн зэвсгийн ээлжит туршилтаа хийхээр бэлтгэж байгаа тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаатай холбогдуулан Монголын тал сэтгэл зовниж байгааг илэрхийлэв.

Хятад улсын элчин сайд өөрийн улсын байр суурийг тайлбарлаад, цөмийн зэвсэг эхэлж хэрэглэхгүй байх л хамгийн чухал асуудал гэв. Хятад улс туршилт хийхдээ байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээ авдаг гэж мэдэгдэв.

1993.09.28. Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбат ОХУ-ын Ерөнхийлөгч Б. Ельцины үйл ажиллагааг дэмжиж илгээлт явуулав. Ерөнхийлөгч П.Очирбат Оросын Холбооны Улсад болж буй үйл явдалтай холбогдуулан Үндэсний аюулгүй байд-

лын зөвлөлийг шуурхай хуралдуулж, ОХУ-ын дотоод байдлын талаарх Монгол улсын байр суурийг илэр хийлэв.

Бүгд Найрамдах Турк Улсад албан ёсны айлчлал хийж буй Монгол Улсын Их Хурлын дарга Н. Багабанди тэргүүтэй төлөөлөгчид 9-р сарын 21-нд Анкарагийн нисэх онгоцны буудалд хүрэлцэн ирэв.

Мөн өдөр Н. Багабанди Х. Жиндорук нар хэлэлцээ хийж, Монгол улсын Их Хурал, Бүгд Найрамдах Турк улсын Үндэсний Их Хурлын хоорондын хамтын ажиллагааны тухай протоколд гарын үсэг зурав.

Туркийн Ерөнхийлөгч С. Демирель УИХ-ын дарга. Н. Багабандийг хүлээн авч уулзаж, эрт дээр үеэс уламжлалт хоёр ард түмний найрамдалт харилцааг цаашид гүнзгийрүүлэх, эдийн засгийн болон соёл боловсролын салбарт хамтран ажиллах асуудлаар санал солилцов.

Туркийн Ерөнхийлөгч Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж, ардчиллыг хөгжүүлж буйг Турк улс тууштай дэмжиж, өөрийн туршлага, бололцооны хүрээнд Монгол улсад дэмжлэг тусалцаа үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв. УИХ-ын дарга Н. Багабанди Туркийн Ерөнхийлөгчид талархал илэрхийлээд, түүнийг Монгол улсад албан ёсоор айлчлахыг урьсан Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбатын урилгыг гардуулав. Н. Багабанди тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид Турк улсын анхны ерөнхийлөгч Ататуркийн бунханд цэцэг өргөж, Анкара хотын байдалтай танилцаж, Анатолийн соёл, иргэншлийн музейг үзэж сонирхов.

1993.09.29. Монгол улсаас Данийн Вант улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж. Ганибал Данийн хатан хаан хоёрдугаар Маргаретад итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.10.01. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганд оролцохоор Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн тэргүүтэй төлөөлөгчид Нью-Йорк орохоор мордлоо. УИХ-ын гишүүн Ж. Болдбаатар Австралийн нийслэл Қамберра хотод 9-р сарын 13—18-нд болсон Олон улсын Парламентын Холбооны (ОУПХ) 90-р бага хуралд оролцоод ирлээ.

1993.10.02. Монгол улсаас Испаний Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х. Бэхбат Испанийн Ван нэгдүгээр Хуан Карлост Итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.10.07. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганд оролцож буй Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Беларусь, Дани, Казахстан, Сингапур, Турк, Энэтхэгийн Гадаад харилцааны сайд нар болон АНУ-ын төрийн нарийн бичгийн даргын туслах Уинстон Лордтой тус тус уулзан, санал солилцов. Тэрээр ЮНИСЕФ-ээс зохиосон дугуй ширээний уулзалтад оролцов. Тус уулзалтаас хүүхдийн янз бүрийн өвчлөлтийг арилгах зорилтыг 2000 он бус 1995 он гэхэд хэрэгжүүлэхийг улс орнуудад уриалсан байна.

1993.10.08. БНХАУ энэ 10-р сарын 5-нд Шинжаан Уйгарын өөртөө засах орны Лоб нуурын районд цөмийн зэвсэг турш-

сантай холбогдуулан Монгол улсын Гадаад харилцааны яамнаас мэдэгдэл гаргав.

1993.10.13. Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Б. Ельцинээс Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад илгээмж ирүүлж «Ардчиллын хувь заяаг шийдвэрлэх хүнд бэрх өдрүүдэд Оросын Ерөнхийлөгчийг дэмжсэнд талархал илэрхийлсэн байна.

1993.10.16. АНУ-аас саяхан мэдэгдэл гаргав. Уг мэдэгдэлд: Монгол улс, АНУ хоёул нэгдэж орсон цөмийн зэвсгийг үлдэлгэрүүлэх тухай 1968 оны гэрээний зарчмуудад Монголын Засгийн газар үнэнч байгаагаар илэрхийлж байдаг бөгөөд түүний үзэл санааны дагуу Монгол улсыг цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласныг АНУ-ын Засгийн газар үнэлж байна. Мөн 1995 онд Цөмийн зэвсгийг тодорхой бус хугацаагаар сунгахыг Монгол улс дэмжсэнийг бид сайшааж байна.

Хэрэв Монгол улс Хэзээ нэгэн цагт аюул заналтай тулгарч, асуудлыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд тавибал АНУ Зөвлөлийн бусад гишүүний хамт зохих арга хэмжээний асуудлыг авч хэлэлцэх болно гэж цохон тэмдэглэсэн байна.

1993.10.21. Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай олон улсын гаалийн байгууллага болох Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Том Хейсийг хүлээн авч уулзаж олон улсын болон Монголын гаалийн байгууллагын хамтын ажиллагааны цаашдын чиглэл, Худалдаа тарифын ерөнхий хэлэлцээр (ГАТТ) -т Монгол Улс нэгдэн орохтой холбогдсон асуудлаар санал солилцов.

1993.10.21. Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н. А. Назарбаев гэргийн хамт манай оронд албан ёсны айлчлал хийхээр хүрэлцэн ирлээ. Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат, БНКазахстан Улсын Ерөнхийлөгч Н. А. Назарбаев нар Төрийн хүндэтгэлийн өргөөнд уулзан ярилцаж, мөн өдөр хэлэлцээ хийв. Н. А. Назарбаев Монгол Улсын Их Хурлын ажиллагаанд оролцож үг хэлэв. Тэрээр хоёр орны Парламентын цаашдын хамтын ажиллагааны талаар УИХ-ын дарга Н. Багабандитай санал солилцов. Ерөнхийлөгч П. Очирбат, Ерөнхийлөгч Н. А. Назарбаев нар Монгол Улс, БНКаз. Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээнд гарын үсэг зурав. Ерөнхийлөгч Н. А. Назарбаев манай оронд айлчлах явцдаа монголын казах иргэдийн төлөөлөгчидтэй уулзаж ярилцан «Говь», «Тэмүүжин мэнч» компанид зочилж, монголын бизнесменүүдтэй уулзав. Мөн Хэвлэлийн бага хуралд гадаадын болон казахстан, монголын сэтгүүлчдийн сонирхсон олон асуултад хариулав.

1993.10.26. Лондон хотноо, Монгол, Их Британийн дугуй ширээний уулзалтад оролцсон УИХ-ын Байнгын хорооны дарга Г. Цэдэндагва Эрхэмсэг Гүнж Аннад бараалхаж, хоёр орны харилцааны асуудлаар санал солилцов. Мөн Монголын төлөөлөгчдийг Нэгдсэн Вант Улсын ГЯЯ-ны сайд А. Гудлэд хүлээн авч уулзав.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж. Энхсайхан БНХАУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэй Зя И-тэй уулзаж хоёр орны харилцааны зарим асуудлаар санал бодлоо солилцлоо. Монгол Улс өөрийгөө цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан Монгол Улсын санаачилгыг Хятад улс сайшаан дэмжиж байгаа бөгөөд Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг хүндэтгэхээ элчин сайд илэрхийлэв.

1993.10.29. Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Монгол Улсаас Шведийн Вант Улсад суух өргөмжит консулын гэрчилгээг Шведийн иргэн, хатагтай Анита Герднел гардуулав. Хатагтай А. Гердне нутагтаа худалдааны ажил эрхэлдэг ажээ.

1993.10.30. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганд оролцож буй манай төлөөлөгчдийн гишүүн ГХЯ-ны Олон улсын байгууллагын хэлтсийн дарга Л. Баярт улс төрийн асуудал эрхэлсэн I хорооны хуралдаан дээр үг хэлж, зэвсэг хураах асуудлаар Монгол Улсын байр суурийг илэрхийлэв. Тэрбээр хэлсэн үгэндээ цөмийн зэвсэггүй бүс, цөмийн туршилт, зэвсэглэл дэх ил тод байдал, Тэсрэх дэлбэрэх бодисыг аюулгүйгээр илрүүлэх зэрэг цөмийн болон ердийн зэвсэг, мөн түүнчлэн химийн зэвсгийг хориглох тухай конвенцын хэрэгжилттэй холбогдсон асуудлуудыг хөндөж ярилаа.

1993.11.04. Монгол Улсаас Ватикан улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ш. Юмжав Ромын пап хоёрдугаар Йон Павелд итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.11.05. Цөмийн зэвсэггүй бүс болох Монгол Улсын саналыг дэмжин АНУ-аас гаргасан мэдэгдэлтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтонд илгээлт явуулж манай улсын санал хүчин чармайлтыг дэмжиж байгаад талархал илэрхийлэв. Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг Их Британи, Умард Ирландын Вант Улс дэмжиж мэдэгдэл гаргалаа. Ийнхүү Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг цөмийн зэвсэгтэй таван гүрнээс ОХУ, АНУ, БНХАУ, Их Британи хүндэтгэж дэмжихээ мэдэгдэв.

1993.11.06. Бүгд Найрамдах Израиль Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Моше Бен Яков Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Итгэмжлэх жуух бичгээ барив.

1993.11.09. Нидерландын Вант Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дирк Ян Ван Хоутен Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатад Итгэмжлэх жуух бичгээ барив.

Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Л. Даваагив, Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн дэд ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч С. Бурки нар Монголын эдийн засгийн өөрчлөлтийг дэмжихэд зориулан. Дэлхийн банкнаас олгох 20 сая ам. долларын зээлийн хэлэлцээрт Вашингтон хотноо гарын үсэг зуржээ.

Парис хотноо болж байгаа ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 27 дугаар чуулганд гадаад харилцааны тэргүүн дэд сайд ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын дарга Ж. Чойнхор тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Төлөөлөгчидтэй ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Федерико Майор уулзаж ирэх хоёр жилд Монгол, ЮНЕСКО-гийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар ярилцав. Чуулганы бүгд хуралдаан дээр Ж. Чойнхор үг хэлж, Монгол улс, ЮНЕСКО-гийн хамтын ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлсэн байна.

1993.12.05. Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай энэ 1993 оны 11-р сарын 24-28-нд Японы Засгийн газрын урилгаар Япон улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Цог Жавхлант Эзэн хаан Акихитод бараалхаж, Парламентын төлөөлөгчдийн танхим, Зөвлөхүүдийн танхимын дарга нартай уулзаж, Ерөнхий сайд М. Хосокаватай хэлэлцээ хийсэн байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын танхимын гишүүн, Худалдаа үйлдвэрийн сайд Ц. Цогт, Япон улсын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд Ц. Хата нар «Агаарын харилцааны хэлэлцээр», «Соёлын буцалтгүй тусламж», «Зээл авах тухай» болон «Буцалтгүй тусламжийн» ноот зэрэг баримт бичигт гарын үсэг зурсан байна. Япон улсаас манай оронд Төслийн бус буцалтгүй тусламжийн хоёр тэрбум иен, төмөр замын салбарын хүчин чадлыг дээшлүүлэхэд зориулж 30 сая долларын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, соёлын буцалтгүй тусламжаар Гадаад хэлний дээд сургуулийн танхимыг тоноглоход зориулж 50 сая иен олгох боллоо. Айлчлалын өдрүүдэд Япон, Монголын найрамдал, хамтын ажиллагааны олон нийтийн байгууллагууд худалдааны танхим, түүнчлэн японы компаниудын нэгдсэн холбоо зэрэг ажил хэргийн хүрээнийхэнтэй өргөн уулзалт зохион байгуулсан байна. Монгол Улсад өөрчлөлт, шинэчлэлт өрнөсний үр дүнд хоёр орны харилцаа эрх чөлөө, ардчилалын шинэ шатанд дэвшсэнийг Ерөнхий сайд М. Хосокава сэтгэл ханамжтай тэмдэглээд Монгол Улсын өөрчлөлт, шинэчлэлтийн төлөө хүч чармайлтыг Япон Улсын Засгийн газар цаашид ч идэвхитэй дэмжин туслахаа мэдэгдэв. Ерөнхий сайд П. Жасрай Токиогийн хэвлэлийн төвд айлчлалын дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийлгэж, сэтгүүлчдийн асуултад хариулав. П. Жасрай тэргүүтэй Монголын Засгийн газрын төлөөлөгчид Японы Нагая Осака, Киото хотуудад зочилж, хөдөө аж ахуй, корпорацууд, үйлдвэр, худалдааны танхимын үйл ажиллагаатай танилцав. Ерөнхий сайд П.Жасрай Японы Парламентын гишүүн, Ерөнхий сайд асан Т. Кайфутай уулзаж ярилцсан байна. Ноён Т. Кайфу одоо Япон, Монголын эв нөхөрлөлийн нийгэмлэгийг толгойлж байна.